

МОНГОЛЧУУДЫН ЭКОЛОГИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ УЛАМЖЛАЛ БА СЭТГҮҮЛ ЗҮЙ

Л. Норовсүрэн*, Х. Энхтуяа**

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор, профессор.

** ОТИС, сэтгүүл зүйн магистр, докторант.

Түлхүүр үг: экологийн сэтгэлгээ, экологийн соёл, заяагдмал эзэд, тэнгэр эцэг, газар эх, байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал.

Шинэ сэтгүүл зүйн нэг чухал чиглэл, даяаршиж байгаа дэлхий ертөнцийн тулгамдсан асуудлын нэг нь экологийн асуудал болж байна. Монголын сэтгүүл зүй харьцангуй богинохон түүхтэй ч үүссэн цагаасаа эхлэн экологийн асуудлыг тасралтгүй тусгаж иржээ. Сэтгүүл зүйн түүхэн туршлагыг нягталж үзвэл экологийн сэдвийг тусгаж ирсэн явцыг дараах байдлаар томъёолж болох юм. Үүнд нэгдүгээрт; Тогтмол хэвлэл, мэдээллийн хэрэгслээр байгалийн баялгийг ашиглах, хамгаалах сэдэвтэй урсгал нийтлэл гарч байсан үе (1913-1970 он), хоёрдугаарт; Байгаль хамгаалах асуудал төрийн бодлогын хэмжээнд тавигдаж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чухал сэдэв болсон үе (1970-1990 он), гуравдугаарт; Экологийн сэдвийг байнга тусгадаг сэтгүүл зүйн тусгай чиглэл буй болсон үе (1990 оноош хойш) хэмээн ангилж болохоор байна. Энэ ангилал нь зөвхөн бодит сэтгүүл зүйд экологийн асуудлыг тусгаж ирсэн байдлыг харуулж байгаа бөгөөд бүхэлдээ монголчуудын

экологийн соёлын уламжлалд тулгуурлаж, түүнийг өвлөн үргэлжлүүлсэн агуулгатай болохыг онцлон анхаарах нь чухал юм.

Монголчууд экологийн эртний соёлтой ард түмэн юм. Бидний өвөг дээдэс эрт цагаас үр ач нараа байгаль орчин, эх нутагтаа хайр хүндэтгэлтэй ханддаг болгон хүмүүжүүлж иржээ. Тэд байгаль орчныхоо заяагдмал эзэд болохын хувьд гол горхийн эхнээс мод огтлох, усанд улаан цагааныг оруулах, хог үнсээ ил задгай хаях зэргийг эрс цээрлэж, залуу үедээ сургамжлан сэрэмжлүүлж заншсан байдаг. Амьтан, ургамлыг нь алж, тасдаж болдоггүй онгон догшин газар хэмээн ярилцдаг нь ч мөн л хайрлаж хамгаалах санаанаас үүдэлтэй юм. Тэр ч чанараараа Монголчууд уул усаа анх түрүүнд онголон дархалсан ард түмний тоонд ордог. Ерөөсөө Монголын утга соёлын дурсгалуудад тэнгэр эцэг, газар эхээ дээдлэн шүтэх үзэл шингэсэн байдаг нь нэн эртнээс уламжилсан бөө мөргөлийн ёс заншилтай холбоотой ажээ.

"Их засаг" (XIII зуун), "Алтан хааны цаазын бичиг" (XVI зуун), "Халх журам" (XVIII зуун) зэрэг хууль цаазын дурсгалуудад хүн, байгаль хоёрын зохицон орших зүй тогтлыг

танин мэдэж, байгаль орчин, ургамал амьтныг хамгаалах асуудлыг төрийн бодлогын хэмжээнд тавьж байсныг харуулах мэдээ баримт үлэмж байна. Чингис хааны "Их засаг"-т "Бэлчээрийн газрыг эвдэж сүйтгэгчдийг хүндээр шийтгэнэ. Өвс ногоорсон хойно газар нүхэлсэн багал алдаж, бэлчээр шатаагчдыг гэр бүлийн хамт алах хэрэгтэй" (34-р зүйл) гэжээ. Аргамжааныхаа гадасны нүхийг бөглөж бай, газрын чийг хатна. Исгэрч салхи бүү хөдөлгө,

ногоо ургамал гандана гэж хууччуул сургадаг нь уг хууль ард түмний амьдралын мөрдлөг, хэв заншил болж өвлөгдсөнийг харуулдаг.

Монголчуудын экологийн сэтгэлгээ нь байгалийн хишгийг зөв зохистой хүртэх, хайрлан хамгаалах, өсгөн арвижуулах цогц шинжтэй хөгжиж иржээ. Манай ард түмэн эрт үеэс хүнснийхээ нилээд хэсгийг ан гөрөөсний махаар хангадаг байсан хэдий ч тэдгээр амьтныг хайргамтай, зүй зохистой ашиглан, өсч үржих нөхцлийг хангах экологийн эрхэм соёлтой байжээ. Энэ тухай Италийн алдарт жуулчин Марко Поло-гийн тэмдэглэлд "Их хааны Захиргааны бүх газар нутаг чухамхүү үнэн голыг өгүүлэхэд гуравдугаар сараас аравдугаар сар хүртэл ан амьтан үржих, төлжих үед ямар ч хан ван, ноёд сайд, ер хэн хүн ч бүх төрлийн амьтан, марал буга, туулай, чандага, зээр гөрөөс мэтийг авладаггүй, хэрэв зөрчвөл хатуу цээрлүүлэхийг Их хааны Зарлигаар тогтоосон ажээ"¹ гэсэн байдаг. Түүнчлэн XIX зууны Монголын төрийн

зүтгэлтэн, шинэтгэгч үзэлтэн Б.Тогтохтөр "Аж төрөхүйг заасан сургаал"-даа "Тамхины нүгэл ихийн дээр галаас эндэгдэн түймэр алдагдаж хүнд ялд холбогдох тул дахин чандлан зогсоон тушаагтун" хэмээн өөрийн харьяаны ард олонд зарлиг болгож байжээ.

Монголын эрдэмтэн мэргэд олон зууны тэртээгээс экологийн тэнцвэрт байдлыг хадгалах санааг дэвшүүлэн тавьж байсан гэж үзэж болно. Монголын бичгийн их хүн

«
**Монголын эрдэмтэн мэргэд олон
зууны тэртээгээс экологийн
тэнцвэрт байдлыг хадгалах
санааг дэвшүүлэн тавьж байсан
гээж үзэж болно. Монголын
бичгийн их хүн Цахар гэвш
Лувсанчүлтэм ирээдүйд цаглашгүй
гай гамшиг тарьж болзошгүй муу
үйлийн эх суурь тавигдаж байгааг
одоогоос 200 гаруй жилийн
тэртээ зөгнөн бичиж байжээ.**
»

Цахар гэвш Лувсанчүлтэм ирээдүйд цаглашгүй гай гамшиг тарьж болзошгүй муу үйлийн эх суурь тавигдаж байгааг одоогоос 200 гаруй жилийн тэртээ зөгнөн бичиж байжээ. Тэрбээр байгаль, нийгмийн

амьдралд гарч байгаа зохисгүй өөрчлөлтүүдийг "Таван цөв" хэмээх ойлголтод хамруулан авч үзсэний дотор байгаль орчны эвдрэл сүйрлийг багтаасан нь нэн гайхамшигтай юм. Учир нь Цахар гэвшийн эмзэглэн анхааруулж байсан байгаль орчны эвдрэл сүйрэл өнөөдөр жинхэнэ цөвүүн цагийн гамшгийг зөгнөж, дэлхийн нийтийн анхаарлыг татах болжээ.

Монголчуудын экологийн сэтгэлгээний нэг чухал чиглэл нь байгаль ертөнцийн зүй тогтлыг танин мэдэж, сөрөг нөлөөг арилгах, зохицох явдал байжээ. Их зохиолч В.Инжиннаши "Хөх судар" романыхаа тэргүүн дэвтэрт Монгол орны байгаль орчин, газар нутгийн үржил шимийн тухай бичихдээ "Газар орны хөрс шорооны чадал мөхөсхөн, салхи дэгдвээс

шар хомог хийсч, тэнгэр газар нийлж алсдаа халина. Уул нь хөрс бэлчээр тааруу, говь цөл нь ангамал, гол мөрөн нь үзүүр гаравч дотроо шингэн шургана. Алслагаас их далайд гадагш гарна. Цагийн амьсгал жижүүн хувирган, нарны ээлт хол алс, үр жимс оройтно, хяруу цас эрт..." гэсэн нь байгаль орчноо танин мэдэж улмаар зүй зохистой харилцаж, ашиглах санааг илэрхийлсэн санаа юм.

Манай ард түмний байгаль орчин, газар нутгаа судлан мэдэж, баялгийг нь зохистой ашиглах бодлогын уламжлалыг бодит сэтгүүл зүйн эхлэлийг тавьсан анхны тогтмол хэвлэл "Шинэ толь хэмээх бичиг" өвлөн авсан байдаг. ОНМХ үүссэнээр урд нь эрдэмтэн мэргэдийн ном зохиолд мэр сэр үзэгддэг байсан ч олон нийтэд төдийлөн хүрч чадаагүй байсан байгаль орчны сэдэв тогтмолжиж, үр нөлөө нь сайжирсан байна.

Монголчуудын экологийн сэтгэлгээнд байгалиа хайрлан хамгаалах үзэл зонхилж иржээ. Энэ нь байгаль орчноо танин мэдсэний үр дүн байв. Монголын мэргэд өөрийн газар нутгийн эрс тэс уур амьсгалтай, ус чийг бага, хөрс ургамал ядмагийг танин мэдээд хайрлан гамнахгүй бол сүйрэлд хүрч болзошгүйг угтан харж байжээ. "Шинэ толь хэмээх бичиг"-ийн анхны дугаарт "Манай монгол орон болбоос Азийн төв дунд байх бөгөөд Өмнөд их далай ба Дорно зүгийн их далайн алинаас ч алслан холдсон тул хур бороо, ус мөрөн ховор. Иймээс элдэв газрын гарц үржилгүй, хүн аж төрөхөд ашиг хонжоо бага, ихэвчлэн цөл говь нутаг болой"² гэсэн нь Монголын хөрс, ургамлын байдалд тохирсон экологийн харилцаа хэрэгтэйг сануулсан хэрэг байна.

Мөн сонинд нийтлэгдсэн "Хөлөн буйр мужийн загас ашигласан тухай" гэдэг өгүүлэлд Богд хаант монгол улсын засгийн газрын зөвшөөрлөөр нийтдээ 50 шахам газарт гадаад, дотоодын хүмүүс загас агнаж байгаа бөгөөд тэдгээр чадах, чадахгүй хүмүүс загасыг зохисгүй аргаар барьж, бүр мөсөн устгах аюул нүүрлэж байгааг шүүмжилжээ. Загас агнах цаг улирлыг зааж өгдөггүй, явцад нь хяналт тавьдаггүйгээс түрслэх цагт хамаагүй агнах, тор, хаалт хэрэглэж хоморголон барих зэрэг зохисгүй явдал гарсаар байгааг Шодокаво Рогаливе гэдэг гадаадын хүн хаалт хийж үлэмж тооны загасыг бөөнөөр хураасан баримтаар иш татаад эцэст нь "Гагцхүү манай "Шинэ толь"-ийн хороо Монголын эрх баригчдад сануулах нь; Монгол улсын газраа бусад улсын адил агнуурын дүрэм хэмжээ нарийвчлан байгуулж, загасыг хавар намрын түрслэх цагт агнахыг огт хориод, загасны газрыг олонд зарлаад үнэ хаялцуулан хүн таньж өгөхөөс гадна, загасыг бүрэлгэх, сүйтгэх ба хориглосон цагт агнахыг нягтлан байцааж, хүмүүс айл томилж суулгаваас сайн болов уу хэмээн сануулъя. Улсын хөрөнгө, дэлхийн аливаа баялгийг алгуураар бүрэлгэн хоосруулж яахин болмуй. Улсын газраа бүхий алт, мөнгө, нүүрс, төмөр хүртэл элдэв баялгийг хэмжээ болгоомжлолгүй ашиглаваас хэдхэн оны дотор хөрөнгөө юүлэн хоосорч, улс төрийн ачаа даах тэнхээ барагдах нь ажил муутай хүний үгүйрэх лүгээ адил болой"³ хэмээн байгаль орчин, түүний баялагт хайхрамжгүй хандах нь улс үндэстний аюулгүй байдалтай ч холбогдож болохыг анхааруулж байжээ.

"Шинэ толь хэмээх бичиг"-ийн 1913 оны 5 дугаарт Чита хотод суух орос Барон хэмээх хүн Монголын

хойд хязгаарын гурван харуулын газраас таван жилийн дотор 15 түмэн мод огтолж Онон голоор урсган аваачих гэрээ хийхээр Гадаад яамныхантай уулзсан тухай өгүүлээд "Өчнөөн үлэмж улсын хөрөнгийг хялбараар өгч хяргуулан, ой цэцэрлэг хоосорч, ус булаг хатахуй дор хүрвээс даан ч харамсалтай... Гадаад улсын мод ашиглахыг үзвээс гагцхүү арвилахыг эрхэмлэн, дарга цагдаа суулгаж, хулгайлан огтолж гэмтээхийг сахиулна" гэсэн бол тус сонины 1914 оны 10 дугаарт "Монгол улсын харьяат газраа ер ой мод ховортой, хур бороо, ус цас ч элбэггүй бөгөөтөл жил бүр түймэр алдаж, хайран ой мод юугаан хий гэмтээж, ус булгийг хатган, дэлхийн баялгийг даанч үл хамгаалах, үл бодох нь хэтэрчээ" хэмээн харамсан бичсэн байна. Мөн өгүүллийн эцэст бас "Манай монгол улсын түшмэд, ард аль нь адил гамнах, хэмнэх, хамгаалах, сахих, хураах, үржүүлэхийг суртал болговоос зохино" гэсэн байна. Мөн сонины 1914 оны 14 дүгээрт бас Хүрээний хүн ам олширч түлш, хашаа байшин зэрэгт залуу модыг хэмжээлшгүй ихээр огтлон авах болсноор "ойр хавийн модыг үржих аргагүй болгож, бүрмөсөн барагдуулахад хүрсэн" тухай өгүүлээд модны оронд түлшинд нүүрсийг, барилгад шавар тоосгыг ихээр хэрэглэх санал тавьж байжээ.

Сонины эрхлэгч Ж.Цэвээн байгаль хамгаалах үйлсэд анхаарч ялангуяа ой мод, ус булаг, загасны нөөцийг зохистой ашиглахад санаа сэрэмж болохуйц өгүүлэл, материал нийтэлж байсны дээр өөрөө "Богд хан уулын магтаал" гэдэг цуврал нийтлэлийг "Нийслэл хүрээний сонин бичиг"-т гаргасан нь Монголын уул тайгын бүсийн ургамал, амьтны аймгийн

цогцолбор болсон дархан цаазат уулынхаа халдашгүй, ариун дагшин байдлыг өргөн дуулахад чиглэж байжээ.

Монголын хувьсгалт хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслүүдэд ч байгаль орчны асуудал хөндөгдсөөр ирсэн байна. Улс орны бүтээн байгуулалтын цар хүрээ тэлж, үйлдвэрлэл хөгжихийн хэрээр хүнээс байгальд үзүүлэх нөлөө ихсэж ирсэн үед нийгмийн сэтгэл зүй дан ганц хайрлан гамнах сэтгэлгээнээс байгалийг эрхшээх, өөрчлөх сэтгэлгээнд шилжсэн байдал ажиглагддаг. Тухайлбал хориод оны дунд үед гарч байсан "Ардын эрх" сонинд нийтлэгдсэн "Болгоомжилсоор боогджээ" гэдэг өгүүлэлд "Ой модны хэрэг, тариалангийн явдал, чулуун нүүрсний ажил, загас агнах явдлын цаг хэдийнээ болсон бөгөөд хянах, болгоомжлох улирал эрт өнгөрч, одоо идэвхлэн гүйцэтгэх цаг болжээ" гэсэн бол мөн сонины "Өөрийн хөрөнгийг бадруулж өөр тийш төөрөгдөн мөлжигдөхөөс ангижирна уу" гэсэн бичлэгт "Агнах, гөрөөлөх явдалд хэмжээ тогтоол гарган, гадаадын хүмүүс зоргоор агнаж, ангийн баялгийг сүйтгэх явдлыг чанд хориглон зогсоож, анг улсын нэгэн зүйл чухал орлого болговол зохино" гэх мэтээр бичиж байжээ.

Тус сонинд бас байгалийг хувирган өөрчилж амьдрал ахуйдаа ашиглах санааг ч дэвшүүлэн тавьж байв. Эрхлэгч Ц.Дамбадорж сониныхоо "Эдийн засаг" гэдэг буланд Сэлбэ голын усыг боож, сан байгуулан эрчим хүч гарган авах зоримог санал дэвшүүлж, үндэслэл тооцоотой зүйл бичжээ. Уг өгүүлэлд "Сэлбэ гол усаар элбэг, өвлийн хүйтэнд үл хөлдөх булаг бүхий гол учраас хотоос дээш найман модны хэр сүмийн орчим усыг боож, уртаар долоо буюу зургаан мод, өргөнөөр

нэг буюу гурван модны газар ус хуралдуулан нуур болгож нэг хоолойгоор урсгавал хэдий хуурай гантай цагт ч гэсэн усны хүч нь төсөөлөн бодвол 500 морины хүч хэртэй болох тул Улаанбаатар хотноо үйлдвэрийн оньст хүрдийг хөдөлгөн явуулахад эрч хүч нь элбэг хүрэлцэж, хотын хүн ам уух цэвэр устай болно. Усыг бооход 12 түмэн янчаанаас үл хэтрэнэ" гэхчилэн бичсэн байна. Хэрэв хүн, байгаль хоёрын харилцааны асуудал экологийн үндсэн судлагдахуун мөн гэвэл дээр дурдсан баримтуудыг экологийн сэдэв гэж үзэхээс өөр аргагүй юм. Дурдсан жишээ-нүүдээс харахад Монголын сэтгүүл зүйн хөгжлийн эхэн үед байгаль орчныг хайрлан хамгаалах, зөв зохистой ашиглах

хоёр зорилтын аль аль нь чухал сэдэв болж байжээ. Үндсэндээ ХХ зууны жараад оны эцэс хүртэл байгалийн баялгийг ашиглах, түүнийг улс орны эдийн засгийн нэг үндэс гэж үзэх, бичих явдал тогтмол хэвлэлд давамгайлж байсан юм.

Далаад оны эхэн үеэс "Байгаль хамгаалах сарын ажил"-ыг орон даяар жил бүр зохион байгуулж, уг ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилдаг болсон нь энэ асуудал төрийн бодлогын хэмжээнд тавигдсантай холбоотой байв. Энэ үеэс байгаль хамгаалах асуудал хурцаар тавигдсан нь бодит шалтгаантай юм. Шинжлэх ухаан, техникийн дэвшилттэй холбоотойгоор ХХ зуунд хүнээс байгальтай харилцах харилцаанд нэг янзын

түрэмгийлэл бий болж, үүний улмаас биологийн төрөл зүйлүүдээс гадна эргээд хүний болон нийгмийн экологид аюул нүүрлэх болсон юм. Тийм нөхцөл байдал нь нийгэм, хүн, хүрээлэн буй орчны харилцан нөлөөлөх зүй тогтлыг нээж, байгаль орчныг хамгаалах асуудлыг урьд байгаагүй ихээр дэвшүүлэн тавихыг шаардсан байна. Төрийн бодлого ч энэ зүгт чиглэж эхэлсэн юм. Жар, далаад онд Газар эдэлбэрийн болон Байгаль орчныг хагаалах эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн бол ерээд

оноос Экологийн эрх зүй шинжлэх ухааны шинэ чиглэл, эрх зүйн бие даасан шинэ салбар болжээ.

Соёл иргэншилт ертөнц тогтвортой хөгжлийг стратегийнхээ зорилт болгож байгаа өнөө үед нийгэм-эдийн засгийг

экологийн чиг баримжаатай хөгжүүлэх нь үндэсний төдийгүй, олон улсын ач холбогдолтой болж ирэв. Дэлхий нийтийн энэхүү чиг хандлагыг нийгмийн толь болох сэтгүүл зүй тусгахгүй байх аргагүй тийм цаг үед бид аж төрж байна.

Орчин үед экологийг организм хүрээлэн буй орчинтойгоо хэрхэн харилцахыг судалдаг шинжлэх ухаан, түүнчлэн организмын амьдралын үйл ажиллагааны зүй тогтлыг төрөлх орчинтой нь, түүнд хүний нөлөөллөөр бий болсон өөрчлөлттэй нь холбон судалдаг шинжлэх ухаан гэж үзэх болжээ. Тэгвэл тэрхүү амьд организм орчинтойгоо харилцаж байгаа байдал, хүрээлэн буй орчинд үзүүлж байгаа хүний нөлөөллийг тусгах хэрэгцээ шаардлагаар

«
Орчин үед экологийг организм хүрээлэн буй орчинтойгоо хэрхэн харилцахыг судалдаг шинжлэх ухаан, түүнчлэн организмын амьдралын үйл ажиллагааны зүй тогтлыг төрөлх орчинтой нь, түүнд хүний нөлөөллөөр бий болсон өөрчлөлттэй нь холбон судалдаг шинжлэх ухаан гэж үзэх болжээ.
»

экологийн сэтгүүл зүй үүссэн байна. Монголчуудын хувьд экологи гэдэг харьцангуй шинэ ойлголт боловч экологийн сэтгэлгээний хувьд эртний уламжлалтай болохыг өмнө өгүүлсэн билээ. Тэрхүү уламжлалт сэтгэлгээ орчин үеийн экологийн сэдэвт нийтлэлд шууд нөлөөлсөн гэж үзүүштэй юм. Сэтгүүл зүй судлаачид өнгөрсөн зууны наяд оны хоёрдугаар хагасыг Монголын сэтгүүл зүйд экологийн сэдвийг хамгийн их бөгөөд үр нөлөөтэй тусгасан үе гэж үздэг. Үнэхээр ч тэдгээр он жилүүд бол төр, нийгэм, байгууллага, хувь хүн, өөрөөр хэлбэл байгаль орчинтой харилцдаг субъектүүд бүхэлдээ өөрсдийн буруу үйлдлээс унаган байгальдаа учруулсан хор хөнөөлийг ухаарч эхэлсэн үе байлаа. Өөрчлөлт шинэчлэлийн уур амьсгал орж, сэтгүүлч нийтлэлчид санасан бодсоноо харьцангуй зоригтой илэрхийлэх болсон явдал ч экологийн сэдвийг хөндөхөд түлхэц болж байв. Энэ үед Ц.Балдоржийн "Далай ээж минь цаазын тавцанд"⁴, "Далай ээжийг цаазлахаар зэхэж байна"⁵, "Хүйн холбоотой Хөвсгөл, Байгаль хоёр"⁶, Ш.Цэен-Ойдовын "Зарлигаар дархалсан ууланд зэрлэгээр халдах эрх олгожээ"⁷, Г.Жамцын "Эх орны ногоон хүрэм сэглэгдэж байна"⁸, Ц.Дашдоржийн "Улаан номын хуланг махны агуулахад үзсэний мөрөөр"⁹ гэх зэрэг чансаатай нийтлэлүүд гарчээ. Эдгээр нийтлэлийн дараа жирийн иргэнээс эхлээд нам, төрийн удирдах дээд байгууллага хүртэл байгаль орчинд болгоомжгүй хандаж байгаадаа дүгнэлт хийж, зарим алдаатай бодлого, үйл ажиллагаанаасаа татгалзсан шийдвэрийг хүртэл гаргаж байв. Түүнчлэн сэтгүүлч Ц.Балдоржийн бичиж байсан "Ганц жил наслуулах гэж арван сар тээдэг үү"¹⁰, "Тойрч гарахын аргагүй хурц асуудал"¹¹ зэрэг нь өнөө үед чухлаар

тавигдаж байгаа хүний экологийн сэдвээр бичсэн анхны дорвитой нийтлэл болсон юм.

Ийнхүү цаг үеийн шаардлагаар Монголын сэтгүүл зүйд экологийн сэдэв түрэн орж ирсэн нь зүйн хэрэг. Гэтэл экологи гэдэгт чухам юуг, ямар хүрээнд ойлгох вэ? сэтгүүл зүйд түүнийг хэрхэн тусгах вэ? гэдэг асуудал энэ үед хурцаар тавигдаж байна. Уламжлалт онолын ойлголтоор бол аливаа салбарын мэдлэг бие даасан ухагдахуун байхын үндсэн хоёр шалгуур нь тухайн салбарын судлах зүйл бодитой оршиж, судлах арга төлөвшин тогтсон байх учиртай. Энэ утгаар нь авч үзвэл ерээд онд экологийн сэтгүүл зүй Монголын сэтгүүл зүйн шинэ салбар болж чаджээ. Экологийн тэнцвэрт байдлыг хадгалж хамгаалах нь нэг улс орны хүрээнээс хальж дэлхий даяарын асуудал болсон, хүн ард бид экологийн сүйрэл болж байгаатай өдөр тутам тааралдаж түүний уршигт үр дагаврыг мэдрэх болсон, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд экологийн сэдвийг идэвхитэй хөөцөлдөж, тусгах объект, түүнд тохирсон арга барилаа сонгон тогтоосон зэргийг юуны өмнө дурдах хэрэгтэй. Ийм хэмжээнд хүрэхэд юуны өмнө экологийн харилцааны тухай шинжлэх ухааны ойлголтоос эхлэх хэрэгтэй байсан нь мэдээж билээ.

Энэ нь байгаль бол өөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцаа холбоо бүхий нэгдмэл тогтолцоо мөн гэж үзэх явдал мөн. Байгалийн харилцаа, тухайлбал түүний нөөц баялаг өөр хоорондоо болон гадаад дотоод орчинтойгоо хувьсан өөрчлөгдөж, зохицон оршиж байх нь экологийн харилцааны мөн чанар юм. Экологийн харилцаа нь нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны

амьдралд анхдагч шинжтэй бөгөөд соёл иргэншлийн өндөр төвшинд ч энэ чанараа хадгалж байх зүй тогтолтой. Хэрэв энэ зүй тогтолт мөн чанар алдагдвал байгаль ертөнц түүнийг даган тэнцвэрээ алдаж, хүн төрөлхтөн үгүйрэн хоосорч, үхэж мөхөхөд ч хүрч болзошгүй билээ. Ингэхээр экологийн харилцааг жам ёсны нь дагуу тэнцвэртэй барьж байх явдал хүн төрөлхтний оршин тогтнохын үндсийн үндэс болж таарч байна.

Чухам үүнээс л экологийн сэтгүүл зүй, түүний тусгах объект аяндаа тодрон гарах учиртай. Юуны өмнө экологийн сэтгүүл зүйн объект улам бүр тэлсээр байгаа нь өнөө үеийн нэг онцлог юм. Энэ нь хөгжлийн төвшин, иргэншлийн байдалтай холбоотойгоор улс орон бүрт ялгаатай байгаа боловч ерөнхийдөө тогтвортой хөгжлийн үндэс болох хүрээлэн буй байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, нийгэм-эдийн засгийг экологийн чиг баримжаатай хөгжүүлэх, байгаль, түүний нөөц баялгийг ашиглах, хамгаалах, хүн төрөлхтнийг эрүүл, аюулгүй орчинд амьдруулах, байгаль орчны нөхцлийг өнөөгийнхөөс дордуулахгүйгээр хойч үедээ өвлүүлэх зэрэг асуудлыг багтаана. Тодруулбал: Дэлхийн цаг агаарын дулааралт, хотжилт суурьшилтай холбоотой агаар, усны бохирдолт, дуу шуугиан, химийн үйлдвэрийн хаягдал, хорт бодисын нөлөөгөөр ургамал, амьтан сүйрэх үзэгдэл, цөлжилт, хөрсний доройтол, эрүүл биш хүнс хэрэглэх, бохир орчинд аж төрснөөс хүний эрүүл мэнд, удамд учрах сөрөг үзэгдэл зэрэг нь бүгдээрээ экологийн сэтгүүл зүйн тусгах объект юм. Товчоор хэлбэл хүн төрөлхтний тогтвортой хөгжих, эрүүл аж төрөх орчныг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг багтаана.

Өнөө үед "ашиглалт, дахин хуваарилалт, нөөцийг дуусгах замаар тойрон байгаа орчныг өөрчилж буй хүн ба амьтай амьгүй байгалийн хоорондох харилцааг тусгах үйл ажиллагаа", түүнчлэн "Глобал болон орон нутгийн чанартай экологийн эерэг ба сөрөг асуудлыг тасралтгүй тусгадаг үйл ажиллагаа"¹²-г экологийн сэтгүүл зүй гэж үзэх болжээ.

Эдгээр тодорхойлолт өргөн утгаараа зөв боловч цаашид гүнзгийрүүлэн төгөлдөржүүлэх шаардлагатай байгаа нь мэдээж юм. Энэхүү өгүүллийг тэрлэгч түүнд бага ч гэсэн санаа нэмэх үүднээс хүрээлэн буй байгаль орчны дотоод дахь жам ёсны, тэнцвэрт харилцааг хамгаалах, түүний оршихуйд хүн төрөлхтнөөс үзүүлж буй эерэг ба сөрөг нөлөөллийг тусгахад чиглэгдсэн ОНМХ-ийн тасралтгүй үйл ажиллагааг экологийн сэтгүүл зүй гэж үзэх саналтай байна. Энэ тодорхойлолтоороо бид хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тусгасан экологийн сэдэвтэй нийтлэл нэвтрүүлгийг бус, ийм асуудлыг дагнан судалж бичдэг бие даасан хэрэгсэл, тэдгээрт ажилладаг сэтгүүлчдийн мэргэшсэн байнгын үйл ажиллагааг гол шалгуур болгож байна. Энэ шалгуурын үүднээс авч үзвэл экологийн сэтгүүл зүй үйл явцаасаа хоцорч байгаа нь тодорхой юм.

Экологийн харилцааны объект нь байгаль орчин, түүний нөөц баялаг болдог бол, субъект нь энэхүү харилцаанд оролцогч төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болно. Иймээс экологийн сэтгүүл зүйн тусгах зүйл нь энэхүү объектив бодит байдал болох хүрээлэн байгаа орчин, түүнтэй харилцагч субъект болох төр, аж ахуйн байгууллага, хүний үйл ажиллагаа байх болно.

Ертөнцөд хүн үүссэнээр экологийн харилцаанд оролцогч анхдагч объект бий болсон байна. Экологийн объектив харилцаа, хүний субъектив үйл ажиллагааны зохицол нь амьд организмын оршин байхын үндэс, нийгмийн хөгжлийн нөхцөл болдог тул экологийн сэдвийг сэтгүүл зүйд тусгахдаа юуны өмнө байгалийн заяагдмал эзэд болох хүний үйл ажиллагаатай холбон авч үздэг нь зүйн хэрэг юм. Байгальд хүний үзүүлж буй дан ганц сөрөг нөлөөллийг экологийн сэдэв гэж үзэх хандлага нилээд түгээмэл байдаг нь тийм ч бодитой ойлголт биш юм. Хүн бол байгалийг өөрийн зорилгод ашиглахын зэрэгцээ бас түүний до-

тоод зүй тогтлыг ойлгож, тэнцвэрт, эрүүл харилцааг нөхөн сэргээх чадвартай субъект юм. Ийм учраас байгалийн зохицлыг хангах, баялгийг хадгалж хамгаалах, сэргээн төлжүүлэхэд чиглэсэн бүх харилцааг экологийн сэтгүүл зүйн тусагдахуун гэж үзэх үндэстэй.

Нийгмийг зохион байгуулалтад оруулж тодорхой нутаг дэвсгэр, хүн амыг харьяалан захирсан төр улс үүссэнээр экологийн харилцааны хоёрдогч субъект бий болжээ. Төр нь хэдийгээр экологийн олдмол эрхтэй субъект боловч байгалийн нөөцийг ашиглах, хамгаалах харилцааг зохицуулах үүрэг хүлээдэг учраас үлэмж давуу эрхтэйгээр барахгүй бусад субъектийнхээ эрх хэмжээг хуульчлан тогтоож өгдөг юм.

Ингэхээр экологийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь экологийн сэтгүүл зүйн чухал сэдэв мөн. Төр экологийн чиг үүргээ хуулиар баталгаажсан зарчим баримтлан хэрэгжүүлнэ. Тийм гол үүрэг болох хүний амьдрах, хөдөлмөрлөх, амрах явцад байгаль орчны таатай орчин бүрдүүлэх, экологийн баримжаатай нийгэм,

«

Хүн бол байгалийг өөрийн зорилгод ашиглахын зэрэгцээ бас түүний дотоод зүй тогтлыг ойлгож, тэнцвэрт, эрүүл харилцааг нөхөн сэргээх чадвартай субъект юм. Ийм учраас байгалийн зохицлыг хангах, баялгийг хадгалж хамгаалах, сэргээн төлжүүлэхэд чиглэсэн бүх харилцааг экологийн сэтгүүл зүйн тусагдахуун гэж үзэх үндэстэй.

»

зүйн анхаарал төвлөрөх асуудал байх ёстой.

Хүмүүсийн зохион байгуулалттай нэгдэл болох янз бүрийн байгууллагууд нь өөрсдийн зорилго чиглэлийн дагуу экологийн харилцаанд татагдан ордог. Ингэснээр экологийн харилцааны "Байгууллага" хэмээх гуравдагч субъект бий болсон байна. Байгууллагууд нь үүрэг зорилгоосоо хамаарч байгалийн тодорхой хэсэг, төрөл, зүйлүүдтэй харилцаж, эзэмшиж, ашиглаж байдгийн хувьд экологид хүнээс дутуугүй нөлөөтэй юм. Саяхан болтол хүн болоод байгууллагаас экологийн харилцаанд оролцох явцад байгалийн баялгийг ашиглах сэтгэлгээ давамгайлж, нөхөн сэргээх ажил хоцорсоор ирсэн нь нууц биш.

эдийн засгийг хөгжүүлэх, байгалийн баялгийг шинжлэх ухааны үндэстэй, зохистой ашиглах нөхцлийг хангах, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр болон үйл ажиллагаа ил тод байх зэрэг нь экологийн сэтгүүл

Иймд төрөөс энэ сөрөг хандлагыг хязгаарласан хууль тогтоомж, журам зааврыг боловсруулж, хяналт тавьдаг. Тухайлбал уул уурхайн салбарт хуулсан хөрсийг буцааж тэгшлэх, мод бэлтгэлийн аж ахуйд ойг нөхөн сэргээх гэх мэтийг нэрлэж болно. Байгалийн баялгийг нээж ашигласнаас үүссэн сөрөг үзэгдэл, түүнийг багасгах талаар гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нь экологийн сэтгүүл зүйн бас нэг чухал сэдэв мөн.

Улс орон зах зээлийн харилцаанд шилжсэн ерээд онд байгаль орчныг амгаалах ажил үндсэндээ унтарч хувь хүн, пүүс компаниуд эх орны газрын хэвлий, усны гүн, ургамлын нөмрөг, ой хөвч рүү олз хайн дайрч эхэлсэн билээ. Тэдгээрт байгальтай харилцах технологи, ашиглалтын горим гэж бараг байсангүй. Байдал ийм байхад улс төрийн савалгаанд алмайрсан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд байгаль орчны сэдэвт анхаарал хандуулах сэхээ байсангүй. Өөрөөр хэлбэл наяд оны шилдэг уламжлал тасалдсан юм.

Харин сүүлийн жилүүдэд манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд экологийн асуудалд анхаарах нь нэмэгдэж байна. "Зууны мэдээ" сонин Тужийн нарсыг хамгаалах, улмаар нөхөн сэргээх үйлсэд нийт ард түмнийг уриалж, сонины ажилтнууд өөрсдөө үлгэрлэн олон арван суулгац тарьсны дараа алс баруун хязгаарын Увс нутгийнхан хүртэл дэмжиж Тужийн нарсыг сэргээх олон нийтийн өргөн хөдөлгөөн өрнөж эхэлсэн. Түүнчлэн "Үнэн" сонин наяд оны уламжлалаа сэргээж байгаль орчныг хамгаалах сэдвээр хэд хэдэн цуврал нийтлэлийг зэрэгцүүлэн хөтөлж эхэлсэн. Үүнээс хамгийн дорвитой нь тус сонины 2002 оны 89 дүгээрт

сэтгүүлч Б.Мөнхтуяагийн бичсэн "Туул гол биднийг баярлуулдаг ч бид түүнийг гомдоосоор" гэдэг өгүүллээр эхэлсэн "Туул голоо аваръя" хэлэлцүүлэг, мөн оны 95 дугаарт Б.Элдэвийн бичсэн "Хогийг алт болгох эрэлд гарах цаг боллоо" гэсэн өгүүллээс эхэлсэн цуврал нийтлэлүүд юм. Түүнчлэн алтны үйлдвэрүүд газрын хөрсийг сэндчээд нөхөн сэргээлт хийдэггүй, мод бэлтгэлийн аж ахуйнууд ойг үржүүлэхэд хойрго ханддаг хийгээд хулгайгаар мод огтлох, гол горхийн эх, ай савыг бохирдуулах зэрэг зохисгүй үйлдлийг шүүмжлэн мэдээлэх явдал нилээд тогтмолжив. Гэсэн ч анхаарч үзмээр зүйл байсаар байна. Юуны өмнө манай сэтгүүлчдийн экологийн боловсрол нимгэн байна. Тэдний бичсэн зүйл гол ус татарсан, ойн нөөц хомсдсон, хот суурингийн агаар бохирдсон зэрэг нүдний өмнө ил байгаа зүйлийг мэдээлж сэрэмжлүүлэхээс төдий л хэтрэхгүй байгаа нь асуудлаа гүнзгий боловсруулах мэдлэг дутсантай холбоотой юм. Түүнчлэн экологийн нийтлэлийн сэдэв явцуу хүрээнд эргэлдэж байна. Хэвлэлүүд экологийн тулгуур ойлголт болох газрын тухай тун бага бичиж байна. Газар нь амьд организм, хүний нийгэм оршин тогтнохын үндэс болохын хувьд экологийн үндсэн сэдэв юм. Газар нь хөрс, түүний давхрага, бүтэц, үржил шим, хэвлий гэх мэт олон зүйлээс бүрддэг гэдгийг бүгд мэддэг атлаа тэдгээр бүрдэл хэсгүүдэд учирч байгаа хор аюулыг тэгш харж тусгахгүй байна. Тухайлбал газрын хэвлийн тухай нийтлэлийг аль ч сониноос эрээд олдохгүй байх. Орчин үед геологийн судалгаа хийх, ашигт малтмал олборлох, газар дор барилга, байгууламж барих, нефть хайх, тэсэрч дэлбэрэх болон химийн хортой бодис

хадгалах, үйлдвэрийн хаягдал
булах, бохир ус зайлуулах зэргээр
газрын хэвлийг өргөн ашиглах
болов. Эдгээрээс үүдсэн сөрөг
үзэгдлийг бид тэр бүр олж харахгүй
байна. Энэ бүхэнд манай сэтгүүлчид
соргог бөгөөд мэдлэгтэй хандаж,
хэрэг явдлын учрыг тунгааж, ухаан
бодлоо уралдуулсан нийтлэлээрээ
нөлөөлөх явдал дутагдалтай байна.
Өөрөөр хэлбэл байгаль орчны
мөхлөөс урьдчилан сэргийлэхэд
үзгээ хурцалж, үгээ чамбайруулмаар
байна.

Б олж байгаа үйл явц бидэнд
том дохио өгч байгааг сэхээ-
рэх хэрэгтэй байна. Одоогоос
бараг гурван жарны тэртээ Францын
бичгийн эх хүн Г.Флоберийн "Хүний
нийгэм байгаль дэлхийдээ энэ
янзаар хандсаар байх юм бол 2000
жилийн дараа ертөнц дээр ургамал
ч үгүй, мод ч үгүй, ер байгалиас юу ч
үлдэхгүй болно" гэсэн үг өнөөдөр
толгой дээр харанга дэлдэж эхэл-
лээ. Экологийн хэт сүйрэл нүүрлээд
байгааг бүс нутаг, тив, дэлхийн
хэмжээнд хүлээн зөвшөөрөх болов.

1997 онд Америкийн Денвер
хотод болсон "Их найм"-ын уулзал-
таас дэлхий дахиныг хамгийн их
түгшээсэн асуудлаар экологийн
сүйрлийг нэрлэсэн нь манай
сэтгүүлчдээс экологийн боловсролоо
ахиулж, эх дэлхийгээ сүйрлээс
аврахад дуу хоолойгоо чангалах цаг
болсныг анхааруулсан хэрэг юм.

Ишлэл

1. 1987. Орчлонгийн элдэв сонин. УБ. 111
дэх тал.

2. ШТХБ. 1913. №1.
3. ШТХБ. 1913. №4.
4. "Үнэн". 1987. №233.
5. "Үнэн". 1989. №309.
6. "Үнэн". 1989. №153.
7. "Үнэн". 1987. №236.
8. "Үнэн". 1987. №61, 62.
9. "Үнэн". 1989. №120.
10. "Үнэн". 1989. №24.
11. "Үнэн". 1989. №105.
12. Ч о й с а м б а Ч. Экологийн сэтгүүл
зүй. УБ. X. 10.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2000. Монгол улсын төр эрх зүйн үндэс
УБ.
2. Н о р о в с ү р э н Л. 2003. Монголын
сэтгүүл зүйн түүхэн тойм. (Гуравдугаар
бот). УБ.
3. Н о р о в с ү р э н Л. 2004. Монголын
нийтлэл. УБ.
4. 1970. Очерки по истории экологии. М.
5. Ч о й с а м б а Ч. 2002. Экологийн сэт-
гүүл зүй. УБ.

Resume

This article is about an ecological journalism that represents one of the new trends of the free democratic journalism. Here, it is attempted to prove that the ecological journalism is developing being relied on the hundreds years heritage and experience of the mongolian nation's ecological thinking. For this purpose, the things of ecological nature recorded in the ancient mongolian literal sources have been quoted, and their admonitions and modern importance have been evaluated.